



МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Хэрэглэгчийн хяналтын хуудас, заавар т  
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хэрэглэгчийн хяналтын хуудсыг ашиглах зааврыг нэгдүгээр хавсралтаар, хэрэглэгч, үйлчлүүлэгчийн хяналтыг төлөвшүүлэх зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг хэрэглэгч үнэлэх 14 хяналтын хуудсыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан хэрэглэгчийн хяналтын хуудасны ашиглалтанд хяналт тавьж, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хяналтын газар, Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газар, аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ШАРАВДОРЖ

09 0415

## ХЭРЭГЛЭГЧИЙН<sup>1</sup> ХЯНАЛТЫН ХУУДАС ХЭРЭГЛЭХ ЗААВАР

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдэлийн удирдлагын стратегийг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, аж ахуй эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанаас учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах замаар хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангахад хэрэглэгчийн хяналт, хариуцлага, мэдлэгийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор хэрэглэгчийн хяналтын хуудсыг ашиглана.

1.2. Улсын байцаагчийн хяналт шалгалтад хэрэглэж буй хяналтын хуудсыг хялбаршуулан, хэрэглэгч нь үүсч болох аливаа эрсдэлийг тооцон сонголтоо зөв хийх, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээнд үнэлгээ өгөхөд ашиглах хяналтын хуудсыг хэрэглэгчийн хяналтын хуудас гэнэ.

1.3. Хэрэглэгчийн хяналтын хуудсыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас батална.

1.4. Хэрэглэгчийн худалдан авах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чиглэлээр хэрэглэгчийн хяналтын хуудсыг боловсруулж, цаасан болон цахим хэлбэрээр ашиглана.

1.5. Хэрэглэгчийн хяналтын хуудасны асуултыг үйлчлүүлэгч, хэрэглэгч үнэлгээ хийх боломжтой, ойгомжтой, энгийн хэл найруулгаар боловсруулна.

### Хоёр. Хэрэглэгчийн хяналтын хуудсыг хэрэглэх

2.1. Мэргэжлийн хяналтын байгууллагаас батлагдсан хэрэглэгчийн хяналтын хуудсыг байгууллагын [www.inspection.gov.mn](http://www.inspection.gov.mn) цахим хуудсанд байршуулж, олон нийтэд сурталчлах ба хэрэглэгч, үйлчлүүлэгч онлайнаар бөглөх боломжийг бүрдүүлнэ.

2.2. Онлайнаар бөглөсөн хяналтын хуудасны үнэлгээний нэгдсэн дүнтэй хэрэглэгч, үйлчлүүлэгч танилцах боломжтой байх ба мэргэжлийн хяналтын байгууллага тэдний сонголтоо зөв хийх, оновчтой болгох үүднээс холбогдох зөвлөгөө, мэдээллээр хангана.

<sup>1</sup>Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 3.1.1-т заасан хэрэглэгч гэдэг нэр томъёоны хүрээнд ойлгоно.

2.3. Мэргэжлийн хяналтын байгууллагаас хэрэглэгчийн үнэлгээг тандан судлах, хэрэглэгчдэд хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор зохион байгуулалттайгаар олон нийтийг хамруулан хэрэглэгчийн хяналтын хуудсыг цаасан хэлбэрээр хэрэглэж болно.

2.4. Аж ахуй эрхлэгч иргэн, хуулийн этгээд өөрийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор батлагдсан хэрэглэгчийн хяналтын хуудсаар хэрэглэгч, үйлчлүүлэгчдээр үнэлгээ хийлгэн, дотоод хяналтад ашиглаж болно.

2.5. Хяналтын хуудсыг хэрэглэгч, үйлчлүүлэгчээр бөглүүлэхдээ үнэлгээ өгч буй үйлдвэрлэл, үйлчилгээний газрын нэр, байршил, үнэлгээ өгсөн хэрэглэгчийн нэр, холбогдох утсыг заавал бичүүлнэ.

2.6. Үнэлгээ хийлгэхийн өмнө хэрэглэгч, үйлчлүүлэгчид хяналтын хуудасны асуултыг тайлбарлаж, асуулт бүрд шаардлага хангасан бол "тийм", шаардлага хангаагүй бол "үгүй" үнэлгээ өгөх аргачлалыг танилцуулна.

### **Гурав. Үр дүнг ашиглах**

3.1. Төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллага хэрэглэгчийн хяналтын хуудас тус бүрээр үнэлгээг нэгтгэн дүгнэж, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ашиглана.

3.2. Улсын байцаагч тухайн нэг объектод хяналт, шалгалт хийх үед тухайн байгууллагын үйлчилгээ, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэрэглэгч үнэлсэн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, шалгалтын танилцуулгад тусгана.

3.3. Аж ахуй эрхлэгч иргэн, хуулийн этгээд хэрэглэгчийн хяналтын хуудасны үнэлгээнд дүн шинжилгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөхөд ашиглаж болно.

3.4. Хэрэглэгчийн үнэлгээний дүн нь Мэргэжлийн хяналтын байгууллага болон улсын байцаагч тухайн объектод хариуцлага тооцох, хугацаатай үүрэг өгөх үндэслэл болохгүй.